



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2013 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/100

Улаанбаатар хот

Г Тушаалд өөрчлөлт оруулах тухай Г

Засгийн газрын 2012 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам”, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 11 дүгээр тушаалаар батлагдсан “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2012 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн “Сургалтын төрийн сангийн зээлээр гадаадад суралцуулах тухай” А/181 дүгээр тушаалын Банзрагч овогтой Цэрэнтэй холбогдох хэсгийн “Австрали Улсын Маккюарие их сургуулийн” гэснийг АНУ-ын Өмнөд Флоридагийн их сургуулийн” гэж өөрчилсүгэй.

2. Суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Мөнхцэцэг/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дээд боловсролын хэлтэс /П.Эрхэмбулган/-т тус тус даалгасугай.



Л.ГАНТӨМӨР